



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



From
the People of Japan



Save the Children

“ХҮҮХЭД БҮРИЙГ БОЛОВСРОЛД ТЭГШ ХАМРУУЛАХ ЗАРЧМЫГ ДЭМЖИХ НЬ-2” ТӨСӨЛ (2021-2024)

МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС № 5

2023 оны 2-р сар



Нийслэлийн 65 дугаар сургуулийн “Хамтдаа хөгжье” аяны үеэр сурагчид хөгжөөн баясаах тоглоом тоглож байна.
2022 оны 9 дүгээр сарын 30

ДУНД АНГИЙН БАГШ НАРТ ЗОРИУЛСАН НОМ ОРЧУУЛАГДЛАА

2022 ОН

“Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй – дунд ангийн жишээн дээр” хэмээх япон хэл дээрх номыг уг номын зохиогч хатагтай Хисаэ Цукимори болон “Тошбунка” хэвлэлийн газрын албан ёсны зөвшөөрөлтэйгөөр орчуулан гаргалаа.



Бага боловсролын түвшинд хэрэгжсэн өмнөх төслийн хүрээнд 2020 онд хэвлэгдэн гарсан “Сургалтын үйл ажиллагааг дэмжих тусгай хэрэгцээт боловсролын арга зүй – бага ангийн жишээн дээрх 172 шинэлэг санаа” ном нь төслийн зорилтот 16 сургуулийн бага ангийн багш нарын өдөр тутмын сургалтын үйл ажиллагаандаа ашигладаг ширээний ном болж чадсан.

Иймд бага боловсролоос дунд боловсролд дэвшин суралцаж буй тусгай хэрэгцээтэй хүүхдийн шилжилтийн үед нь тэднийг хэрхэн хөгжүүлэх, дэмжих арга зүйн туслалцаа нэн шаардлагатай байсан тул дээрх номын дараагийн цуврал болох уг номыг гаргасан юм.

Өмнөх номын орчуулгыг хийсэн МУБИС-ийн “Хүүхдийн хөгжлийг дэмжих арга зүйн төв”-ийн эрхлэгч, доктор Д.Одгэрэл ахлагчтай баг уг номын зарим нэг агуулгыг орчуулахдаа ХИС-ийн дэмжлэгтэйгээр, мөн номын зохиогч, хэвлэлийн



Зөвлөх О.Мөнхцэцэг анхаарлын дутмагшил, хэт хөдөлгөөнтөх эмгэгтэй хүүхэдтэй хэрхэн ажиллах тухай багш нарт танилцуулга хийж байна. (2022 оны 9-р сар, Монгол-Японы төвийн сургалтын танхим, УБ хот)

газраас зөвшөөрөл авч монгол хүүхдийн нас сэтгэхүйн онцлог, соёл, ёс заншилд тохируулан өөрчилсөн. Хэвлэж гаргасан номын агуулга, арга зүйн сургалтыг 2022 оны 2 болон 9 дүгээр саруудад зорилтот сургуулийн дунд ангийн багш нарт зохион байгууллаа.


Энэхүү номын дагуу БЗД-ийн 79-р сургууль тусгай хэрэгцээтэй хүүхэдтэйгээ хэрхэн ажиллах жилийн ажлын төлөвлөгөө гарган ажиллаж байгаа бол ЧД-ийн 37-р сургууль номын арга зүйн дагуу хүүхдүүдэд мэндчилгээ, гадаад өнгө үзэмж, үс засалт, зохистой үг хэллэг, биеэ авч явах талаар зааварчилгаа өгдөг болжээ.

“Японд хүүхдүүдэд туслах, боловсролд нь хувь нэмэр оруулах зорилгоор анх бичсэн номыг маань Монголд орчуулж, хэрэглэж байгаад би баяртай байна. Номын нэрийг өгөхдөө “санаа” гэсэн үгийг оруулсан байгаа. Тэгэхээр энэхүү номын мэдээллээс авч ашиглахын хажуугаар

Монгол дахь янз бүрийн бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан бусад эх сурвалж, сурган хүмүүжүүлэх арга зүйг илүү дэлгэрүүлж судлаарай. Би Монголын багш нартай уулзаж, сургалт зохион байгуулах тэр өдрийг тэсэн ядан хүлээж байна.” хэмээн номын зохиогч хатагтай Цүкимори сэтгэгдлээ хэлжээ.

Боловсролын тусгай хэрэгцээтэй хүүхэдтэй ажилладаг хүмүүст зориулж номын PDF хувилбарыг монгол хэл дээр гаргасан бөгөөд дараах холбоосоор орж дэлгэрүүлж үзэж болно.

<http://savethechildren.mn/mn/post/1226>



ЗОРИЛТОТ СУРГУУЛИУД ХҮҮХДЭД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХЭРХЭН ЗОХИОН БАЙГУУЛДАГ ВЭ?

2022 ОНЫ 10-12-Р САР

Тэгш хамруулах боловсролын үндсэн зарчим нь хүүхэд бүрийг хувь хүн хэмээн үзэж тэднийг аливаа үйл ажиллагаанд тэгш, хүртээмжтэй оролцуулж байхыг дэмждэг. Төслийн зорилтот сургуулиудын сурагчдын зөвлөл “Үе тэнгийн дэмжигч багш, халамжлагч” бэлтгэн тэдгээр хүүхдүүдтэй хамтран хөгжлийн онцлогтой хүүхдүүдийн сурах хөгжихөд нь дэмжлэг үзүүлэх төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулдаг. 2022 оны хичээлийн жилд зорилтот сургуулиудад зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээллийг та бүхэнтэй хуваалцъя.


“ИДЭВХТЭЙ УНШИГЧ” АЯН

Хэрэгжүүлсэн сургууль: Нийслэлийн Сонгино хайрхан дүүргийн 67 дугаар сургууль

Зорилго: Хөгжлийн онцлогтой сурагчдын унших чадварыг сайжруулах

Үйл ажиллагааны тухай: Ахлах ангийн сурагчдын дунд харааны бэрхшээлтэй сурагчдад зориулсан унших материал

бэлтгэх уриалга гаргаж ахлах, дунд ангийн сурагчид том үсэгтэй ном, тараах материал бэлтгэсэн. Ахлах ангийн сурагчид бага ангийн харааны бэрхшээлтэй, унших чадвар сул хүүхдүүдийг хариуцан авч хичээлийн бус цагаар тодорхой цагуудад хамтдаа уншдаг.



Аяны хүрээнд харааны бэрхшээлтэй сурагчдад зориулсан хийсэн унших материалууд

“СУРАГЧ СОЛИЛЦОО”

Хэрэгжүүлсэн сургууль: Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 37 дугаар сургууль, Өвөрхангай аймгийн 2 дугаар сургууль

Зорилго: Бага ангийн сурагчдыг (хөгжлийн онцлогтой хүүхэд багтсан) дунд ангийн сургалтын үйл ажиллагаанд дасан зохицоход бэлтгэх, сурагчдын идэвх сонирхлыг өрнүүлэх

Үйл ажиллагааны тухай: Энэхүү арга хэмжээнд 20 орчим хүүхэд хамрагдсан. 4-5 дугаар ангийн сурагчдыг (үүнд тусгай хэрэгцээтэй хүүхдүүд багтсан) 6 дугаар ангид, 7-9 дүгээр ангийн сурагчдыг 5 дугаар ангид 7 хоног тус тус солилцон хичээллүүлсэн. Энэ үеэр 6 дугаар ангид суралцаж буй бага ангийн сурагчдыг хичээлийн хуваарийн дагуу хичээлдээ бэлтгэх, хичээл болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанд оролцоход нь туслах “**дэмжигч**” хүүхдүүдийг томилон ажиллуулсан. Мөн ахлах ангийн солилцооны сурагчид дэмжлэг шаардлагатай бага ангийн хүүхдүүдтэй хамт хичээлд сууж, хичээлээ давтах, гэрийн даалгавраа хийхэд нь туслах, хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамт оролцох зэргээр тухайн хүүхдийн “**халамжлагч**” болж тэднийг сургах, хөгжүүлэх ажлуудыг зохион байгуулсан байна.

“ХАМТДАА ХӨГЖЬЕ” АЯН

Хэрэгжүүлсэн сургууль: Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 65 дугаар сургууль

Зорилго: Хөгжлийн онцлогтой сурагчдын оролцох боломжийг нэмэгдүүлэх, тэднийг суралцах чадварыг нэмэгдүүлэх

Үйл ажиллагааны тухай: 5-7 р ангийн сурагчид ба багш нар хөгжлийн онцлогтой сурагчийн онцлог хэрэгцээ, давуу талыг түшиглэн 3 дахь өдөр бүр сурагчидтай үсэг тоо нүдлэх, унших, бичих, зураг зурах хэл яриа хөгжүүлэх, бие дааж бүтээл хийх зэргээр хамтдаа хичээллэдэг.

“НУУЦЛАГ АВЬЯАСТАН”, “БИ ЧАДНА” АЯН

Хэрэгжүүлсэн сургууль: Нийслэлийн Баянзүрх дүүргийн 79 дүгээр сургууль

Зорилго: Хөгжлийн онцлогтой сурагчдын оролцох боломжийг нэмэгдүүлэх, тэднийг авьяас чадварыг нээх.

Үйл ажиллагааны тухай: Сургуулийн нийгмийн ажилтан хөгжлийн онцлогтой сурагчдын талаар судалгааны мэдээлэл цуглуулсан байна. Тухайлбал тэдний хүсэл, сонирхол, чаддаг зүйлс, юунд оролцох боломжтой зэргийг асуумж, ярилцлага хэлбэрээр авч үр дүнг нэгтгэн дээрх аяныхаа төлөвлөлтөд ашигласан.



Нийслэлийн 79 дүгээр сургууль. “Нууцлаг авьяастан” үйл ажиллагаанд оролцож буй сурагчид



Бага ангийн сурагч Б. Батжигүүр ахлах ангийн сурагчдын хамт ном уншиж, хамтдаа тоглож байна. 65 дугаар сургуулийн зан заншлын өргөө

“ТЭГШ ХАМРУУЛАХ БОЛОВСРОЛ- ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ” УУЛЗАЛТ

2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САР

Хүүхдийг Ивээх Сангаас хэрэгжүүлж буй “Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн хүрээнд “Тэгш хамруулах боловсрол-үндэсний хэлэлцүүлэг” уулзалтыг 2022 оны 11 дүгээр сарын 4-нд Блю-Скай зочид буудлын хурлын танхимд зохион байгууллаа. Уулзалтад төслийн зорилтот сургуулиуд болон БШУЯ, НХХЯ, Боловсролын Ерөнхий газар, орон нутгийн Боловсролын газар, Боловсролын үнэлгээний төв, Боловсролын хүрээлэн, ХБХЭЭХ, олон улсын байгууллагуудын төлөөлөл зэрэг нийт 62 оролцогч оролцлоо.

Үндсэн хуралдааны үеэр БШУЯ-аас “Тэгш хамруулах боловсролын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт шийдвэрлэх асуудал”, “Хүүхэд бүрийг тэгш хамруулах зарчмыг дэмжих нь” төслийн суурь судалгааны зөвлөмж, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын комиссын үйл ажиллагааны хэрэгжилт, шийдвэрлэх асуудал, “Тэгш хамруулах боловсролын бодлого эрх зүйн баримт бичигт хийсэн дүн шинжилгээний үр дүн”

зэрэг танилцуулгыг холбогдох албаны хүмүүс хийлээ. Салбар хуралдааны үеэр “ТХБ-ын бодлогын хэрэгжилт”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэхэд нийгмийн салбаруудын хамтын ажиллагааг бэхжүүлэх нь”, “Тусгай хэрэгцээтэй хүүхдийн боловсролын үнэлгээг сайжруулах” сэдвийн хүрээнд оролцогчид бүлгийн хэлэлцүүлэг хийж, цаашид анхаарах асуудлын талаар бодлогын зөвлөмж гаргалаа.



ХИС-ийн Монгол дахь хөтөлбөрийн суурин төлөөлөгч, менежер Л.Баян-Алтай уулзалтыг нээж үг хэлэх үеэр, Блю-Скай зочид буудлын хурлын танхим, 2022 оны 11 дүгээр сарын 4



“Тусгай хэрэгцээтэй хүүхдийн боловсролын үнэлгээг сайжруулах” сэдэвт бүлгийн хэлэлцүүлгийн үеэр, Блю-Скай зочид буудлын хурлын танхим, 2022 оны 11 дүгээр сарын 4



"Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн оношилгоо, хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэхэд нийгмийн салбаруудын хамтын ажиллагааг бэхжүүлэх" сэдвийн бүлгийн хэлэлцүүлгийн үеэр, Блю-Скай зочид буудлын хурлын танхим, 2022 оны 11 дүгээр сарын 4



"ТХБ-ын бодлогын хэрэгжилт, сайжруулах арга зам" сэдвийн бүлгийн хэлэлцүүлгийн үеэр, Блю-Скай зочид буудлын хурлын танхим, 2022 оны 11 дүгээр сарын 4

“ХАМТДАА СУРАЛЦЬЯ” СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА

2022 ОНЫ 11-Р САР



Зөвлөх багш Д.Мөнхцэцэг хичээл зааж байна. 2022.11.28, ХИС-ийн уулзалтын танхим

Сургалтад Дорнод, Дундговь, Дархан-Уул, нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нийт 4 сургууль, 4 цэцэрлэгийн 12 багш, нийгмийн ажилтнууд оролцлоо. Бэлтгэгдсэн чиглүүлэгч багш нар сургуулийнхаа сурагчдын зөвлөлийн гишүүдэд “Хамтдаа суралцъя” гарын авлагаар сургалт зохион байгуулж, тэднийг идэвхжүүлэх сурагчдын дундах үйл ажиллагааг төлөвлөж, зохион байгуулах юм.

Энэхүү гарын авлага нь сургуулийн сурагчид ялангуяа тусгай хэрэгцээтэй хүүхдийн суралцах, хөгжих, оролцох боломжийг нэмэгдүүлэх, тэднийг дэмжих

АХБ-ны “Тэгш хамруулах боловсрол” төслийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Хамтдаа суралцъя” бичил төслийн хүрээнд хүүхдийн дунд зохион байгуулах үйл ажиллагааны чиглүүлэгч багш бэлтгэх “Хамтдаа суралцъя” сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр Хүүхдийг Ивээх сангийн уулзалтын танхимд зохион байгууллаа.

туслах сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулах, сурагчдад нөлөөлөх, оролцоог идэвхжүүлэх ажлуудыг зохион байгуулах “хөтөч” болох ба гарын авлагыг судалснаар сургуулийн сурагчдын зөвлөлийн гишүүд нь оролцоо, манлайллын чадвараа хөгжүүлэх, бусдад эергээр үлгэрлэх, тусгай хэрэгцээтэй хүүхдийн ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх, оролцоог нэмэгдүүлэх, найзлах нөхөрлөх, суралцах үйлд нь туслах ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж, хүнлэг энэрэнгүй, бүтээлч нэгэн болж хариуцлагаа дээшлүүлэх боломжтой юм.



“Хамтдаа суралцъя” сургалт: Чиглүүлэгч багш нар, 2022.11.28 ХИС-ийн уулзалтын танхим

“ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭДТЭЙ МАЛЧИН ЭЦЭГ ЭХЧҮҮДИЙН БИЧИГ ҮСГИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ ЗАМААР ХҮҮХДИЙНХЭЭ СУРЧ ХӨГЖИХ БОЛОН САЙН САЙХАН БАЙДЛЫГ ДЭМЖИХ, ЧАДАВХЫГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСӨЛ

2022 ОН

Энэхүү төсөл нь 2022 оны 6-р сараас хэрэгжиж байгаа бөгөөд төслийн хүрээнд эцэг эхэд зориулсан бичиг үсгийн сургалтыг хосолсон сургалтын арга зүйгээр зохион байгуулах сургалтын модуль боловсруулж, зорилтот Бат-Өлзий, Зүүнбаян-Улаан сумдын Насан туршийн боловсрол нэгж (НТБН)-ийн багш нар болон аймгийн НТБТ-ийн удирдлагууд, мэргэжилтнүүдийг хамрууллаа. Ингэснээр НТБН-ийн багш нар зорилтот бүлэгтэй ажиллах хөтөлбөр боловсруулан бичиг үсгийн сургалтыг танхимаар болон гэрээр зааж байна.



Бичиг үсгийн сургалт нийт **240** цагийн хичээлийн агуулгатай бөгөөд төсөлд зорилтот сумдын нийт **30** эцэг эх, асран хамгаалагч, **18** хүүхэд хамрагдаж байна.

Одоогоор зорилтот сумын НТБН-ийн багш нар хосолсон сургалтын арга зүйгээр онол, дадлага ажил, амьдрах ухааны 50 орчим цагийн хичээлүүдийг ороод байгаа бөгөөд суралцагч эцэг эхчүүдийн хувьд тооцоолон бодох, унших, бичих чадварт нь тодорхой ахиц гарснаар нийгмийн харилцаанд оролцох, гэр ахуйгаа өөд нь татаж цэвэр цэмцгэр байх тал дээр эерэг өөрчлөлт гарч байна. Тэдний цаашдын сурах хүсэл тэмүүлэл өндөр байна. Бүрэг

ичимхий, бараг дуугардаггүй байсан хүүхдүүд гэр бүлийн гишүүдтэйгээ илүү нээлттэй харилцаж, дуу, шүлэг, оньсого цээжлэх, зураг зурах зэргээр цагаа бүтээлч байдлаар өнгөрүүлдэг болсон байна.

Бат-Өлзий сумын НТБН-ийн багш Г.Дуламдорж “Монгол гутал”-ын сургалтыг зохион байгуулж түүндээ төсөлд хамрагдаж байгаа Энхзол охины ээж Орхонтуулыг хамруулснаар охиндоо




Зүүнбаян-Улаан сумын НТБН-ийн багш Ш.Отгонбямба сурагч, малчин Л.Жаргалсайханы гэрт явуулын сургалтын үеэр. Сумын төвөөс 21 км зайд.




Зүүнбаян-Улаан сумын малчин, сурагч П.Сүрэнбаатар. Явуулын сургалтын үеэр. Сумын төвөөс 7 км зайтай.

өөрийн гараар монгол гутал хийж өгсөн сайхан үр дүн гарчээ. Энэ төслийн нэг давуу тал бол хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд эцэг эхтэйгээ хамт хөгжих боломж



Малчин Л.Жаргалсайханы Монгол хэлний хичээлийн дэвтэр.

олгож, эцэг эх болон хүүхэд тус бүрд нь бичиг үсгийн түвшин болон хөгжлийн онцлогт нь тохирсон сургалтын багц хэрэглэгдэхүүн бэлтгэж өгсөн явдал юм.



Зүүнбаян-Улаан сумын малчин, сурагч М.Баярцэцэгийн хичээлийн дэвтэр.

ЭЦЭГ ЭХИЙН СУРГАЛТ 2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САР

2022 оны 10-р сарын 22-ноос 11-р сарын 29-ний хоорондох хугацаанд эцэг эхчүүдэд зориулсан нэг өдрийн сургалтыг төслийн зорилтот сургуулиуд болон Насан туршийн боловсролын төвүүдэд зохион байгууллаа. Энэхүү сургалт нь “Хүүхдийн сурах үйл явцад эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх арга зүй” модулийн агуулгад тулгуурлан 4-9 дүгээр ангийн хүүхдүүдийн эцэг эхчүүдэд тэгш хамруулах боловсролын талаар ерөнхий ойлголт өгөх, шилжилтийн насны хүүхдүүдэд туслах төрөл бүрийн арга зүй, хүүхдүүдээ дэмжих арга барилд сургах зорилготой байв. Сургалтад зорилтот сургууль, Насан туршийн боловсролын төвүүдийн 4-9 дүгээр ангийн сурагчдын нийт 1,571 эцэг, эх хамрагдлаа.

Сургалтын үеэр эцэг эхчүүд кейс судалгаан дээр үндэслэн бага ангиас дунд анги руу шилжихэд хүүхдүүдэд тулгардаг бэрхшээл, асуудлуудын талаар багаар ярилцаж, тэдгээр асуудлуудыг даван туулахад туслах боломжит шийдэл, санааг багаараа хэлэлцэн танилцуулсан юм. Сурагч багш нар холбогдох мэдээллийг өгч, практик дасгал хийн хамтран ажиллалаа. Сургалтын

өмнө болон дараа оролцогчдын мэдлэг болон ойлголтыг тодорхойлох зорилгоор сорил авсан. Сорил нь нийт 10 асуулттай бөгөөд нийт 15 оноо авах боломжтой. Нийт оролцогчдын өмнөх сорилын дундаж оноо нь 6.1, дараах сорилын дундаж оноо нь 10.7 байсан нь сургалтын дараа оролцогчдын мэдлэг, ойлголт 4.6 оноогоор буюу 31.4 хувиар өссөнийг харуулж байна.




37-р сургуулийн оролцогчид сургалтын дүрмээ тодорхойлон, сургалтын зорилго, хэрэгцээний талаар ярилцаж байна. 2022 оны 11 дүгээр сарын 8



79-р сургуулийн оролцогчид мөс хагалах дасгал ажиллаж байна. Сургуулийн сургалтын танхим, 2022 оны 10 дүгээр сарын 31

“НОМТОЙ НӨХӨРЛӨӨ” БҮТЭЭЛЧ АЯНЫ ҮЗЭСГЭЛЭН

2022 ОНЫ 12 ДУГААР САР



“Шидэт аялал” сэдэвт бүтээл, Үзэсгэлэнгийн үеэр, ЕБ-ын 7 дугаар сургуулийн хурлын танхим, 2022 оны 12 дугаар сарын 9

“Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих нь-2” төслийн хүрээнд Ховд аймгийн Ерөнхий боловсролын 7 дугаар сургууль “Номтой нөхөрлөө” бүтээлч аяныг 2 дахь удаагаа зохион байгуулж, холбогдох үзэсгэлэнг 2022 оны 12 сарын 9-ний өдөр амжилттай зохион байгууллаа.



“Номтой нөхөрлөө” бүтээлч аяны үзэсгэлэнд тус сургуулийн 2-6 дугаар ангийн 22 бүлгийн нийт 809 сурагчийн цэвэр бичгийн дэвтрийн үзэсгэлэн, номын тэмдэглэл, мөн хүүхэд бүр эцэг эхтэйгээ хамтран уншсан үлгэрийн дүрүүдээр тухайн үлгэрийн үйл явдлыг харуулсан макет, хуруун хүүхэлдэй, эсгийгээр хийсэн үлгэрийн баатрууд гэх мэт 1,500 гаруй бүтээлүүд танилцуулагдсан юм.

“Номтой нөхөрлөө” аян нь бага ангийн сурагчдын унших чадварыг нэмэгдүүлэх, ярианы ур чадварыг нь хөгжүүлэх, улмаар алдаагүй, цэвэр бичих чадварыг нь сайжруулах зорилготой байсан юм. Тус аяны хүрээнд хүүхэд бүр үлгэрийн баатруудаа амилуулан бүтээлээ хийсэн. Бүтээлээ хийхдээ эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд эцэг эхтэйгээ хамтран ажилласан нь гэр бүл дотор эцэг эх, хүүхдийн харилцааг илүү бүтээлч, идэвхтэй болгосон ба хүүхдийн хөгжил, төлөвшилд эерэг нөлөөтэй байсныг олон эцэг эх, багш нар дурдаж байлаа. Энэхүү үйл ажиллагааны үр дүнд эцэг эхчүүдийн хүүхэдтэйгээ харилцах харилцаа сайжирч, тэдний сурлага, хүмүүжилд анхаарал хандуулах нь нэмэгдэж, эерэг хандлагатай болж байна.

Энэ хичээлийн жил эхэлснээс хойш хүүхэд бүр цэвэр бичиг, номын тэмдэглэл хөтөлсөн дэвтрүүдээ үзэсгэлэнд тавихаар тасралтгүй 4 сарын турш хичээж оролцсон нь энэ үйл ажиллагааны онцлог байлаа. Цэвэр бичиж сурах нь хүүхдийн дэвтрийн

үйл ажиллагаа, цэгцтэй байдал, бие даах чадварыг хөгжүүлдэг бол номын тэмдэглэл хөтлөх нь уншсан зүйлийг тунгаан бодох, нэгтгэн дүгнэх, өөрийн сэтгэгдэл, үзэл бодлоо зөв, эмх цэгцтэй илэрхийлэх чадварыг хөгжүүлдэг.

Бүтээлийн үзэсгэлэнгийн үеэр орон нутгийн телевизээр 5 дугаар ангийн сурагч Э.Ундрах-Эрдэнэ номын тэмдэглэл хөтөлсөн бүтээлч аргаа хуваалцсан бол 3 дугаар ангийн сурагч О.Ариунзаяа уншсан номуудаасаа өөрт таалагдсан “Алттай домбо” үлгэрийг ярьж, үлгэрээс ойлгосон сургамжит санаагаа хүүхдүүдэд хуваалцлаа. Мөн эцэг эхийн төлөөлөл Н.Бат-Өлзий хүүтэйгээ хамтран Алунгоо эхийн үлгэрийн баатруудыг эсгийгээр урласан ба бүтээлийг хийх явцад хүүдээ туслахаас илүүтэйгээр өөрөө ч мөн хүүгээсээ олон зүйлийг сурснаа онцлон хэлж байлаа. Төслийн хүрээнд зорилтот сургуулиудад хүүхэд бүхэн тэгш эрхтэй, тэгш оролцоотойгоор суралцаж, хөгжиж байна.



Үзэсгэлэнгийн "Улсэр ярих цаг" сэдэвт бүтээлийн хэсэг, ЕБ-ын 7 дугаар сургуулийн хурлын танхим 2022 оны 12 дугаар сарын 9



5Г ангийн сурагч Ундрах-Эрдэнэ телевизийн ярилцлага өгч байна. Үзэсгэлэнгийн үеэр, ЕБ-ын 7 дугаар сургуулийн хурлын танхим 2022 оны 12 дугаар сарын 9



Аяны хүрээнд сурагчдын уншсан номын тэмдэглэлүүд, ЕБ-ын 7 дугаар сургуулийн хурлын танхим 2022 оны 12 дугаар сарын 9

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН АРВАЙХЭЭР СУМЫН 2 ДУГААР ДУНД СУРГУУЛИЙН 9Е АНГИЙН СУРАГЧ П.АМАРТАЙВАНЫ ТҮҮХ



Сурагч П.Амартайван бүтээлээ урлаж байна. Арвайхээр сумын 2 дугаар дунд сургуулийн хөдөлмөрийн хичээлийн танхим

Сурагч П.Амартайван: Миний хувьд сургуулийнхаа ердийн ангид суралцах гэдэг нэг талаараа мөрөөдөл нөгөө талаараа айдас байсан. Анх орж ирэхдээ битүүхэн айдастай, хүүхдүүд намайг дээрэлхэн ялгаварлах болов уу? Хичээл ордог багш нар маань намайг ойлгох болов уу? гэсэн бодол байсан. Гэтэл хэсэг хугацааны дараа бид ойлголцож, ангидаа зөндөө олон найзтай болсон. Хичээлдээ хамт явна, мөн хичээлээ тараад гэр рүүгээ хамт явна. Надад үнэхээр сайхан байдаг. Найзууд маань надад маш их тусалж, ойлгодогт би маш их баярладаг. Мөн хичээлээс гадуурх цагаар найзтайгаа усан загвар, нисэх загварын дугуйланд явж тэмцээнд оролцсон бас урлагийн үзлэгт жүжигчилсэн тоглолтод оролцсон гээд анги хамт олонтойгоо маш олон өөрчлөлт, шинэ сорилтуудыг би даван туулсан. Одоо ангийнхан, багш маань намайг хамгийн ихээр дэмждэг, ойлгодог хүмүүс болсон. Би одоо ангийн багштайгаа, ангийнхантайгаа хамт хичээлээс гадуурх

ажил зохион байгуулахад хамгийн их дуртай, энэ жилийн шинэ жилийг ангиараа тэмдэглэсэн нь мартагдахааргүй дурсамжтай өдрийн нэг болсон доо.

Ангийн багш О.Одгэрэл: Сурагч Амартайван маань анх 2013 онд 6 настайдаа "Оюуны ундраа" сургуульд элсэн орж, 2019 онд манай 2 дугаар дунд сургуулийн тусгай бүлэгт элсэж орсон түүхтэй. Тусгай ангиас ердийн ангидаа шилжээд 2 дахь жилдээ суралцаж байна. Энэ хугацаанд ангийнхантайгаа үл ойлголцох, хэл ярианы хөгжил сул болохоор өөрийгөө илэрхийлж чадахгүй байх зэрэг хүндрэл бэрхшээл гарч байсан ч эргээд энэ нь найз нөхөдтэй болж нэгнийгээ улам илүү ойлгох хөшүүрэг нь болсон. Тэр ангийнхаа хүүхдүүд болон найзуудыгаа бусдаас маш их өмөөрч хамгаалдаг. Одоо сурагч хүү маань хөдөлмөрийн хичээлийн хөгжүүлэх сургалтаар макет хийх, усан загвар, нисэх загвараар суралцаж эхэлсэн бөгөөд

уралдаан тэмцээнд оролцож өөрийгөө улам илүү хөгжүүлж нээж байгаад нь би баярлаж, үргэлж дэмжихийг хүсдэг. Хамгийн сүүлд Нарийнтээл суманд болсон усан загвар болон нисэх загварын бүтээл хийх “Ирээдүйн инженерүүд” аймгийн аварга шалгаруулах тэмцээнд нисэх загвараар П.Амартайван тусгай байранд шалгарсан амжилт үзүүлээд байна.



Сурагч П.Амартайван хийсэн усан онгоцны загвар

ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Улаанбаатар хотын гурван дүүрэг, Өвөрхангай болон Ховд аймгийн зорилтот сургуулиудын бага, дунд ангийн хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

ТӨСЛИЙН ЗОРИЛТУУД

- 1 Зорилтот сургуулийн 5-р ангийн сурагчдыг дунд ангид дэвшин суралцахад дэмжлэг үзүүлэх;
- 2 Суурь боловсролын түвшинд тэгш хамруулан сургах боловсролын тогтолцоог бий болгох;
- 3 Зорилтот сургуулийн эцэг эхчүүдэд хүүхдийнхээ анги дэвших болон цаашид суралцах үйл явцад туслахад дэмжлэг үзүүлэх;
- 4 Төслийн үр дүнд амжилттай хэрэгжсэн загвар, үйл ажиллагааг сурталчлах, тэгш хамруулан сургах боловсролын төрийн бодлогод тусгах

ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭГЧ

Япон улсын Гадаад Хэргийн Яам

ТӨСЛИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА

3 жил (2021 оны 3 сар - 2024 оны 3-р сар)

ТӨСЛИЙН ҮР ШИМИЙГ ХҮРТЭГСЭД:

Шууд: 20,606 **Шууд бус:** 28,650

ТӨСӨЛД ХАМРАГДАЖ БҮЙ ЕБС-ИУД

Баянзүрх дүүргийн 79, 127, 30-р сургууль,
Амгалан цогцолбор сургууль
Чингэлтэй дүүргийн 37, 49, 39, 61-р сургууль
Сонгинохайрхан дүүргийн 67, 65, 9, 76-р сургууль
Өвөрхангай аймгийн 2-р сургууль, Уянга сумын 1-р сургууль
Ховд аймгийн 7, 3-р сургууль



🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар
☎ +976-11-329365, +976-11-329371
✉ +976-11-329361
✉ Mongolia.secretary@savethechildren.org

🌐 www.savethechildren.mn
🇮🇳 Save the Children in Mongolia
🇺🇸 Save the Children MN
🇲🇳 HaaaraaUlgerley